

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.100, 13.220.99

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага	MNS 5390:XXXX
Occupational Safety and Health Occupational safety and hygiene. Electrical fire safety. General requirements	MNS 5390:2004-ийн оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын ... оны ... дүгээр сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалаар батлав.

Энэ стандарт нь ... оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Зорилго

Энэ стандартын зорилго нь цахилгаан хэлхээг галын аюулгүй ашиглах шаардлагыг тогтоож, байгууллага, аж ахуйн нэгж, ажилтнуудын амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, эд хөрөнгийн галын аюулгүй байдлыг хангахад оршино.

2 Хамрах хүрээ

Энэ стандартаар цахилгаан сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалтын зөрчлөөс шалтгаалан иргэний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн эд хөрөнгөнд галын аюултай байдал үүсэх, осол гэмтэл учрахаас урьдчилан сэргийлэх, цахилгаан хэрэгсэл, тоног төхөөрөмжийг зохион бүтээх, угсралтын зураг төсөл зохиох түүнийг үйлдвэрлэх, угсрах, турших, тохируулах, ашиглахад тавих галын аюулгүйн шаардлагад хамаарна.

3 Норматив эшлэл

Энэ стандартад дараах стандартуудаас иш татсан ба тэдгээрт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалыг ашиглана .

MNS 5150, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Цахилгааны аюулгүй ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага

MNS 4244, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Цахилгааны аюулгүй ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага

4 Нэр томьёо, тодорхойлолт

4.1

Цахилгааныг галын аюулгүй ашиглах

Цахилгаан сүлжээ, тоног төхөөрөмжийн холболт, угсралт ашиглалтыг галын аюулгүйн шаардлагад нийцүүлэх үйл ажиллагаа

4.2

Зөвшөөрөгдөх гүйдэл

Дамжуулагч утасны халалтыг тооцож тогтоосон гүйдлийн их утга

4.3

Богино холбоо

Цахилгаан шугам сүлжээ ба цахилгаан хэлхээний хүчдэлтэй цэгүүд маш бага эсэргүүцлээр холбогдох цахилгаан гүйдэл

4.4

Шилжилтийн эсэргүүцэл

Цахилгаан гүйдэл нэг дамжуулагчаас хөндлөн огтлолын өөр талбайтай нөгөө дамжуулагчид шилжихэд тэдний хүрэлцэн нийлсэн талбайн гадаргууд үүссэн эсэргүүцэл

4.5

Хэт ачаалал

Цахилгаан сүлжээний гүйдлийн хэмжээ нь техникийн үзүүлэлтээр тогтоогдсон гүйдлийн хэмжээнээс хэтрэх үзэгдэл

5 Цахилгааны галын аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага

5.1 Цахилгаанаас үүсэх гал түймрийн шалтгааныг дараах байдлаар ангилна.

5.1.1 богино холбооноос үүсэх гал түймэр

5.1.2 хэт ачааллаас үүсэх гал түймэр Богино холбоо, хэт ачаалал, шилжилтийн эсэргүүцэл, аянгын үйлчлэлийн улмаас гал түймэр гарахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх

5.1.3 Газардуулгын системийг зөв сонгож гүйцэтгэх

5.1.4 Цахилгаан хөдөлгүүр, хуваарилах самбар, залгаж, салгах хэрэгслийн хамгаалалтын зэргүүд нь орчны нөхцөлд тохирсон, цахилгаан техник ашиглалтын дүрмийн шаардлагыг бүрэн хангасан байх

5.1.5 Цахилгаан тоноглолын ашиглалтын дүрмийн шаардлагыг хангах

5.1.6 Үзлэг үйлчилгээ, их болон урсгал засваруудыг ашиглалт аюулгүй ажиллагааны дүрэмд заагдсан хугацаанд нь хийх .

5.1.7 Цахилгаан шугам сүлжээ, тоноглолын зураг, төсөл, тооцоог батлагдсан зургийн дагуу гүйцэтгэх

5.1.8 Цахилгаан шугам сүлжээ, тоноглол нь байгалийн гэнэтийн болон бусад гадны нөлөөлөлд өртөж гэмтэн галын аюул үүсэхээс урьдчилан сэргийлэх

5.1.9 Цахилгаан шугам сүлжээ, тоноглолын угсралт холболтын ажлыг зөвхөн цахилгааны мэргэжлийн хүнээр гүйцэтгүүлэх

6 Богино холбоо, хэт ачаалал, шилжилтийн эсэргүүцлээс үүсэх гал түймрээс хамгаалах

- 6.1** Галын аюулаас урьдчилан сэргийлэхийн тулд дараах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 6.1.1** Цахилгаан шугам сүлжээг богино холбооны гүйдлээс хамгаалах зориулалтын хэрэгсэл, тоноглолыг тавьж ашиглах
- 6.1.1** Цахилгаан дамжуулагчийн гүйдлийн ачааллыг түүнээс хамааран үүсэх халалтын тогтоогдсон дээд утгаас хэтрүүлэхгүйгээр тооцоолох
- 6.1.2** Гүйдлийн ачааллын тооцоонд хамрагдаагүй хэрэглэгчийг нэмж залгахгүй байх
- 6.1.3** Нэг цэгт олон төрлийн цахилгаан хэрэглэгчийг залгахгүй байх
- 6.1.4** Цахилгаан дамжуулах хэлхээний холбох хэрэгслүүдийг тухайн ачаалалд тохируулан сонгох
- 6.1.5** Дамжуулагчийн хэвийн ачаалалд тохируулан давхар болон бусад залгуурыг хэрэглэх, гэмтэлтэй залгуур, үзүүр нь ил задгай дамжуулагч утас ашиглахгүй байх
- 6.1.6** Цахилгаан дамжуулах утаснуудын холбоосыг тогтоосон дүрмийн шаардлагын дагуу найдвартай хийж, зориулалтын тусгаарлах хайрцаг ашиглах
- 6.1.7** Дамжуулагч болон холболтын цэгүүдийн хооронд оч хаях аюул бүхий цахилалт, нэвт цохилт үүсгэхгүй байх нөхцөлийг техник ашиглалтын дүрмийн шаардлагын дагуу бүрдүүлэх
- 6.1.8** Гүйдэлтэй дамжуулагчийн тусгаарлагчгүй ил хэсгийг тусгаарлах
- 6.1.9** Дамжуулагчаар гүйдэл нэвтрэн өнгөрөхөд ялгаран гарч буй дулааны тоо хэмжээ нь энэхүү гүйдлийн квадраттай шууд пропорциональ хамааралтай учир гүйдлийн хүчийг хэвийн байдлаас нэмэгдүүлэхгүй байх
- 6.1.10** Цахилгаан тоног төхөөрөмжүүд тэдгээрийн холбох хэрэгслүүдийн ил гал гарах зүйл, галд тэсвэргүй бодис материал байрлуулахыг хориглох
- 6.1.11** Цахилгаан тоног төхөөрөмжийг хоёр эх үүсвэрээс тэжээх, нэг эх үүсвэртэй бол хос тэжээлийн шугамтай байх, аль нэг нь тасрахад өөр хоорондоо автоматаар залгагдах схемтэй байх .

ТӨГСӨВ.